



**Арилжааны мэдээ**

- 2018 оны 26 дахь долоо хоногт Монголын хөрөнгийн биржээр нийт 3.14 тэрбум төгрөгийн үнэт цаасны арилжаа явагдаж, зах зээлийн үнэлгээ 2.48 их наяд төгрөгт хүрлээ.
- Тус долоо хоногт MSE Top-20 индекс 2.14% өсч 19,961.46 нэгжид хүрсэн бол MSE I индекс 0.27% өсч 9,620.27 нэгж, MSE II индекс 1.91% буурч 9,496.95 нэгжид тус тус хүрлээ.
- Хамгийн их өсөлттэй хувьцаагаар Хөвсгөл алтан дуулга (ADU) 15% өсч 247.45 төгрөг, Хархорин (HNN) 14.29% өсч 1600 төгрөгт тус тус хүрч хаагдлаа.
- Хамгийн их бууралттай хувьцаагаар Монгол Секюритиес (MSC) 27.69% буурч 470 төгрөг, Бэрх Уул (BEU) 14.12% буурч 730 төгрөгт хүрч хаагдлаа.

MSE Top 20 индекс

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Монгол банкны USD/MNT ерөнхий харьцаа

Эх сурвалж: Монгол Банк

	USD/MNT ханш	% Өөрчлөлт
USD	2,462.82	1.46

Тодруулга

Энэхүү арилжааны мэдээ нь зөвхөн арилжааны болон санхүүгийн мэдээлэл өгөх зорилготой бөгөөд аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Энэхүү мэдээнд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд “БиДиСек ҮЦК” ХК хариуцлага хүлээхгүй болно.

Зах зээлийн өөрчлөлт

Индекс	Нэгж	% Өөрчлөлт
MSE Top-20 индекс	19,961.46	2.14%
MSE I индекс	9,620.44	0.27%
MSE II индекс	9,496.95	1.91%

Зах зээлийн хураангуй	Нийт (MNT)
Зах зээлийн үнэлгээ	2,481,879,441,147
Арилжигдсан үнийн дүн	3,149,852,596

Үнийн дүнгээр	Хаалт (MNT)	Мөнгөн дүн
АПУ	633.39	1,208,991,305
ХӨХ ГАН	95	437,973,720
Э-ТРАНС ЛОЖИСТИКС	85	435,176,799
БИ ДИ СЕК	1,100	401,984,800
ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ	650	101,019,349

Тоо ширхэгээр	Хаалт (MNT)	Нийт
ХӨХ ГАН	95	5,152,102
Э-ТРАНС ЛОЖИСТИКС	85	5,119,779
АПУ	633.39	1,881,271
ЛэндМН ББСБ ХК	56.4	1,076,057
ХАЙ БИ ОЙЛ	62.5	445,950

Ханш өссөн	Хаалт (MNT)	% Өөрчлөлт
ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА	247.45	15.00
ХАРХОРИН	1600	14.29
ХӨХ ГАН	95	11.76
ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП	320	10.34
АПУ	633.39	9.64

Ханш буурсан	Хаалт (MNT)	% Өөрчлөлт
МОНГОЛ СЕКЮРИТИЕС	470	27.69
БЭРХ УУЛ	730	14.12
АГРОТЕХИМПЕКС	1075	13.10
БИНСЭ ХК	350	13.04
ДАРХАН ЗОЧИД БУУДАЛ	144	7.10

ЗЗҮнэлгээ өндөр	Хаалт (MNT)	Тэрбум/₮
АПУ	633.39	614.79
ТАВАН ТОЛГОЙ	9,700	527.71
МИК ХОЛДИНГ	11,000	217.45
ГОВЬ	24,020	185.82
СҮҮ	214	71.99

Дараах link-ээр орж арилжааг харна уу: <http://bdsec.mn/trade/>

**ЭНЭ ДОЛОО ХОНОГТ****“ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА” ХК-ИЙН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААГ ТҮР ЗОГСООЛОО (mse.mn)**

- “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн 2018 оны 4 дүгээр сарын 2-ны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар нэмж хувьцаа гаргахаар шийдвэрлэсэн бөгөөд нэмж хувьцаа гаргах хүсэлтийг Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлсэнтэй холбогдуулан үнэт цаасны арилжааг 2018 оны 6 дугаар сарын 29-ний өдрөөс эхлэн зогсоолоо.

“СҮҮ БОНД”-ЫН ЭРГЭН ТӨЛӨЛТ ХИЙГДЛЭЭ (mse.mn)

- МХБ-ийн 1-р ангилалд бүртгэлтэй “Сүү” ХК нь 2017 оны 6 дугаар сарын 29-ний өдөр “Сүү Бонд”-ыг МХБ-ээр дамжуулан арилжаалж олон нийтээс 6 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлсэн нь МХБ-ийн түүхэн дэх хамгийн өндөр дүнтэй компанийн өрийн хэрэгсэл болсон билээ. Тус өрийн хэрэгслийг “Сүү” ХК нь өөрийн хувьцаагаар баталгаажуулан гаргасан бөгөөд жилийн 17.5 хувийн хүүтэй буюу банкны хадгаламжийн хүүнээс өндөр өгөөжтэй байсан нь хөрөнгө оруулагчдын оролцоог нэмэгдүүлсэн гол хүчин зүйл юм.

2018.06.29-ний өдөр “Сүү” ХК нь бонд эзэмшигчдийнхээ дансанд бондын эргэн төлөлтийг хүүгийн хамтаар байршуулснаар хөрөнгө оруулагчдынхаа өмнө хүлээсэн үүргээ 100% биелүүллээ.

“ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЙШН” ХК ӨӨРИЙН ЭЗЭМШИЙН “АЛТАН НАР” ТӨСЛИЙН ТЕХНИКИЙН ТАЙЛАНГ ТАНИЛЦУУЛЛАА (mse.mn)

- “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-д үнэт цаасаа давхар бүртгүүлсэн “Эрдэнэ Ресурс Девопмент Корпорэйшн” (TSX:ERD| MSE:ERDN) нь өөрийн эзэмшлийн Алтан Нар, алт-полиметаллын төслийн хөндлөнгийн техникийн тайланг Канад улсын “Эрдсийн төслийн мэдээллийг олон нийтэд тайлагнах стандарт”-ын дагуу хөрөнгө оруулагч нарт мэдээлсэн байна. Тайланг RPMGlobal (RPM) бэлтгэсэн бөгөөд Канад улсын хувьцаат компаниудын мэдээлэл түгээх цахим талбар болох SEDAR (www.sedar.com)-д “Altan Nar Gold Project. Bayankhongor Aimag. Southwest Mongolia. National Instrument 43-101 Mineral Resource Technical Report” нэртэйгээр хэвлэгдсэн байна.

УИХ-ЫН ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНААР “ТАВАНТОЛГОЙ”-Г ХӨДӨЛГӨХ ТОГТООЛЫН ТӨСЛИЙГ ХЭЛЭЛЦЭНЭ (bloombergtv.mn)

- УИХ-ын Эдийн засгийн байнгын хороо “Тавантолгой” төслийг хөдөлгөх тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг мягмар гарагт хийлээ. Энэ үеэр “Эрдэнэ Тавантолгой” ХК-ийн хувьцааг эзэмшихээс сэргийлж, иргэдэд олгох 1072 хувьцааны бүртгэлжүүлэлтийг эрчимжүүлэх, дээр нь “Эрдэнэ Монгол” ХХК-ийн 49-өөс доошгүй хувийг нийт иргэдэд эзэмшүүлэх хэлбэрээр өөрчлөн зохион байгуулах хуулийн төслийг боловсруулахыг Засгийн газарт үүрэг болгосон байна. Харин энэ лхагва гарагт УИХ-ын чуулганы хуралдаанаар энэхүү төслийг хэлэлцэх товтой байна. Засгийн газар “Эрдэнэ Тавантолгой” ХК-ийн 30 хувьд IPO хийхээр зорьж байгаа бөгөөд IPO хийхэд хамгийн таатай олон улсын Хөрөнгийн биржүүдийг ялангуяа Хонгконгийн Хөрөнгийн биржийг судалж байгаа талаар Уул уурхай, Хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар мэдэгдсэн юм. Мөн “Эрдэнэ Тавантолгой” ХК хувьцаа гаргахад шалгуур үзүүлэлтийг 60-68 хувийг хангаж байгаа гэдгийг мөн онцоллоо. Хэрэв УИХ шийдвэрээ гаргавал 180 хоногт багтаан бэлтгэл ажлаа хангахаар төлөвлөж байна. Мөн бизнесийн болон ордын үнэлгээг хийх, ТЭЗҮ-ийн шинэчлэл, эрсдэлийн анализ хийх, IPO-оос санхүүжих төслүүдийн тооцоо судалгааг хийх шаардлагатай гэж зөвлөх компаниуд дүгнэжээ. Түүнчлэн “Тавантолгой” төслийг хэрэгжүүлснээр нийт 2.8 тэрбум ам.долларын экспортын орлого жилд олно гэж тооцож байна. Улсын төсөвт жилд 400-1.1 тэрбум ам.долларын орлого төвлөрнө, шууд болон шууд бусаар 5800 орчим ажлын байр бий болно гэж тооцож байгаа талаар Уул уурхай, Хүнд үйлдвэрийн яам мэдээллээ.

УУХҮЯ: “ТАВАНТОЛГОЙ”-ИЙН 30 ХУВЬД IPO ГАРГАВАЛ 1.5-6 ТЭРБУМ АМ.ДОЛЛАРЫН ХӨРӨНГӨ ТАТАХ БОЛОМЖТОЙ (bloombergtv.mn)

- УИХ-ын чуулганы баасан гарагийн хуралдаанаар “Тавантолгой” төслийг хэрэгжүүлэх Засгийн газрын саналыг хэлэлцэхийг дэмжиж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороо руу шилжүүлээ. Холбогдох тогтоолын төсөлд УИХ-ын 2010 оны 39 дүгээр тогтоолыг үндэслэн “Эрдэнэ Тавантолгой” ХК-ийн хувьцааны 30 хүртэлх хувийг гадаад, дотоодын Хөрөнгийн биржээр үе шаттайгаар, шаардлагатай хөрөнгө оруулалт татахаар тусгажээ. Одоогоор Хонгконг, Нью-Йоркийн Хөрөнгийн бирж санал ирүүлсэн байна. Мөн БНХАУ-ын А зэрэглэлийн Шанхайн Хөрөнгийн биржид IPO гаргавал бусадтай харьцуулахад 4-6 дахин илүү үнэлэх боломжтой гэж харж байгаа талаар Уул уурхай, Хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар мэдээлсэн юм. Мөн “JP Morgan”, “Goldman Sachs”, “Nomura”, “CICC”, “Deutsche Bank” зөвлөх үйлчилгээ үзүүлэх сонирхолтой байгаагаа илэрхийлсэн байна. IPO гаргаснаар хамгийн багадаа 1.5-2 тэрбум ам.доллар, ихдээ 5-6 тэрбум ам.долларын хөрөнгө татах боломжтой гэж тооцсон талаар Уул уурхай, Хүнд үйлдвэрийн яам мэдээллээ. УИХ шийдвэрээ гаргасны дараа илүү нарийн тооцоог гаргах юм байна.
- Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд “Эрдэнэ Тавантолгой” ХК-ийн 15 тэрбум ширхэг хувьцаа бүртгэгдсэн байгаа ба үүнээс 29.95 хувь буюу 30 орчим хувийг Хөрөнгийн биржээр арилжаалснаар хамгийн багадаа 1.5-2 ам.доллар, ихдээ 5-6 тэрбум ам.долларын санхүүжилт татах боломжтой гэж харж байгаа ажээ. Мэргэжлийн зөвлөх компаниудын үзэж байгаагаар нүүрсний зах зээл сайн байгаа энэ үед санхүүжилт босгох нь зүйтэй гэсэн байна.

ЭНЭ ОНЫ АНХНЫ FPO (bloombergtv.mn)

- Санхүүгийн зохицуулах хороо хурлаараа “Хөвсгөл Алтандуулга” ХК-д нэмж хувьцаа гаргах зөвшөөрөл олгохоор шийдвэрлээ. Тус компани нэмж 4.4 сая ширхэг хувьцаа гарган, 3.7 тэрбум төгрөг татан төвлөрүүлэхээр зорьж байна. Нэмж гаргах хувьцааны 70 гаруй хувийг стратегийн хөрөнгө оруулагчдад, 30 орчим хувийг нь олон нийтэд санал болгож байгаа аж. “Хөвсгөл Алтандуулга” компанийн бизнес үнэлгээгээр нэгж хувьцаа нь 1159-1350 төгрөгийн хооронд байна гэж “BDO” аудитын компани тооцоолжээ. Харин олон нийтэд нэгж хувьцааг 850 төгрөгөөр санал болгох юм. Тус компани татан төвлөрүүлсэн хөрөнгийн 15 хувийг тоног, төхөөрөмж болон сэлбэг авахад, үлдсэн 75 хувийг эргэлтийн хөрөнгө болгохоор төлөвлөж байна. Өөрөөр хэлбэл эргэлтийн хөрөнгөө өсгөснөөр түүхий эдийн нөөцөө нэмэгдүүлж, үйлдвэрлэлийнхээ хүчин чадлыг 80-90 хувьд хүргэхээр зорьж байгаа аж. Ингэснээр 2018 онд борлуулалтын орлогоо найман тэрбум төгрөгт хүргэхээр зорьжээ. Энэ нь 2017 оны дүнгээс гурав дахин өссөн үзүүлэлт юм. Мөн энэ онд борлуулалтын орлого нь өсөхөд оны эхний улирлаас Улаанбаатарт бүтээгдэхүүнээ борлуулж эхэлсэн нь гол нөлөө үзүүлсэн гэж тус компаниас мэдээлж байгаа юм.

“ГАН ХИЙЦ” ХК, “УЛААНБААТАР БҮК” ХК-ИЙН ХУВЬЦААНЫ ХАНШ СҮҮЛИЙН НЭГ ЖИЛД 7-20 ХУВИАР ӨСӨӨД БАЙНА

- Барилгын салбарт үйл ажиллагаа явуулдаг 37 компани Монголын Хөрөнгийн биржид бүртгэлтэй байна. Үүнээс хувьцааны арилжаа нь идэвхтэй байдаг 19 компани байгаа ажээ. Хувьцааных нь ханш урт хугацаандаа өссөн компаниудаас онцолбол “Ган хийц” компанийн хувьцааны ханш сүүлийн нэг жилийн хугацаанд 20 орчим хувиар өсөж, 13 мянга 570 төгрөгт хүрээд байна. Ингэснээр тус компанийн зах зээлийн үнэлгээ 3.3 тэрбум төгрөгөөр хэмжигдэж байгаа юм. “Ган хийц” компани олон нийтэд нээлттэй болсон цагаасаа хойш хувьцаа эзэмшигчдэдээ 12 удаа ногдол ашгаа тараагаад байна. 2017 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 100 төгрөг буюу нийт 24.2 сая төгрөгийг тараажээ.
- Харин Монголын Хөрөнгийн биржийн II ангилалд бүртгэлтэй, барилгын материал үйлдвэрлэгч “Улаанбаатар БҮК” компанийн хувьцааны ханш сүүлийн нэг жилийн хугацаанд 6.8 хувиар өссөн байна. Нэгж хувьцаа нь 425 төгрөгт хүрснээр Монголын Хөрөнгийн биржид тус компанийн зах зээлийн үнэлгээ 55.9 тэрбум төгрөгт хүрээд байгаа юм. Сүүлийн гурван жилийн хугацаанд зогсонги байдалд байсан барилгын салбар сэргээх эхэлсэн талаар “Барилга МН” мэдээлж байна. Үнийн хувьд “Тэнхлэг зууч” компанийн тооцдог орон сууцны үнийн индекс сүүлийн зургаан сар дараалан өсөөд байгаа юм.



О.Уранбайгал

Харилцагчийн албаны менежер
И-мэйл: baigal@bdsec.mn

БиДиСек төв оффис

Залуучуудын өргөн чөлөө 27-1
8-р хороо, Сүхбаатар дүүрэг
Улаанбаатар, Монгол улс
Утас: 976-11-313108
Факс: 976-11-321763

Б.Билгүүн

Харилцагчийн алба, мэргэжилтэн
И-мэйл: bilguun@bdsec.mn

БиДиСек төв оффис

Залуучуудын өргөн чөлөө 27-1
8-р хороо, Сүхбаатар дүүрэг
Улаанбаатар, Монгол улс
Утас: 976-11-313108
Факс: 976-11-321763

Э.Алтансүх

Харилцагчийн алба, мэргэжилтэн
И-мэйл: darkhan@bdsec.mn

БиДиСек Дархан

Дархан-Уул аймаг, Монгол улс
Утас: +976-94082846

Энэхүү арилжааны мэдээ нь зөвхөн арилжааны болон санхүүгийн мэдээлэл өгөх зорилготой бөгөөд аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Энэхүү мэдээнд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд “БиДиСек ҮЦК” ХК хариуцлага хүлээхгүй болно.